ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ТӨВ

МОНГОЛ УЛСАД 2015 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Албан хэрэгцээнд зориулав.

Улаанбаатар хот
2016 он

МОНГОЛ УЛСАД 2015 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Албан хэрэгцээнд зориулав.

Бэлтгэсэн:
Мэдээлэл, статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа Д.Цэвээндулам
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Баяндүүрэн
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Золбоо
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Л.Оюунтунгалаг
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Цолмонхүү
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Х.Энхтуяа
Мэргэжилтэн, цагдаагийн ахмад Э.Батгэрэл
Мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Г.Уянга

Хянасан:
Мэдээлэл, технологийн төвийн дарга, цагдаагийн хурандаа Х.Энхжаргал
мөн төвийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа П.Оюунтунгалаг

Хянасан: Цагдаагийн хурандаа Х.Энхжаргал

Цагдаагийн дэд хурандаа П.Оюунтунгалаг

Формат: А4 /210*297/

Хэвлэлийн хуудас:

Хэвлэсэн тоо: 300

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ 5

Нэг.Монгол улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал 6

§1. Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил 6

§2. Улаанбаатар хотод бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил 13

§3. Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил 64

§4. Зарим төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал 149

§4.1. Хүнийг санаатай алах гэмт хэргийн нөхцөл байдал 149

§4.2. Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн нөхцөл байдал 151

§4.3. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн нөхцөл байдал 153

§4.4. Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал 156

§4.5. Хүчиндэх гэмт хэргийн нөхцөл байдал 158

§4.6. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал 160

§4.7. Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн нөхцөл байдал 173

§4.8. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн нөхцөл байдал 176

§4.9. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэргийн нөхцөл байдал 178

§4.10. Танхайрах гэмт хэргийн нөхцөл байдал 181

§5.11. Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн нөхцөл байдал 184

§4.12. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн нөхцөл байдал 187

§4.13. Зам тээврийн ослын үед жолооч зохих үүргээ биелүүлэхгүй зугтаах гэмт хэргийн нөхцөл байдал 189

§4.14. Албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдал 192

§4.15. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал 192

§5. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал 192

§5.1. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 197

§5.2. Бүлэглэн үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 200

§5.3. Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

§5.4. Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 205

§5.5. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 208

§5.6. Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 211

§5.7. Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 214

§5.8. Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 217

§6. Гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог 219

§6.1. Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 219

§6.2. Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 222

§6.3. Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 225

§6.4. Гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал 228

§6.5. Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал 231

§7. Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик үзүүлэлтүүд 231

§7.1. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, илрүүлэлт, ангилал, төрөл

§7.2. Гэмт хэрэг үйлдэгдсэн онцлог байдал

§7.3. Гэмт хэрэг үйлдэгсэд, тэдгээрийн онцлог

§7.4. Захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлт, саатуулагдсан хүмүүсийн мэдээ

Товчилсон тэмдэглэгээ

АР	Архангай
БӨ	Баян-Өлгий
БУ	Булган
БХ	Баянхонгор
ГА	Говь-Алтай
ГС	Говьсүмбэр
ДА	Дархан-Уул
ДО	Дорноговь
ДД	Дорнод
ДУ	Дундговь
ЗА	Завхан
ОР	Орхон
ӨВ	Өвөрхангай
ӨМ	Өмнөговь
СҮ	Сүхбаатар
СЭ	Сэлэнгэ
ТӨ	Төв
УВ	Увс
ХО	Ховд
ХӨ	Хөвсгөл
ХЭ	Хэнтий
УБ	Улаанбаатар
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг

ӨМНӨХ ҮГ

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн төвөөс “Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал” товхимолыг улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээнд тулгуурлан бэлтгэж, Та бүхэнд толилуулж байна.

Номын агуулга нь өмнөх үг, Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил, тодорхой төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, гэмт хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн онцлогийг тусгасан 6 хэсэг, 31 дэд хэсэгтэй бөгөөд хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор нэр томъёоны тайлбарыг оруулан зарим нэмэлт тодотгол, тайлбар хийсэн болно.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаарх бодлогын төлөвлөлт, төсвийн хөрөнгийн удирдлага, хяналт шинжилгээг тодорхой түвшинд сайжруулах, илүү уялдаатай, зохицуулалттай болгох зорилго нь статистикийн мэдээллийг оновчтой, зөв ашиглах хэрэгцээг нөхцөлдүүлж байна.

Мөн дээрх чиглэлийн судалгаа хийх, гэмт хэрэг, захиргааны зөрчил, гэмт явдлын төлөв байдлыг бодитойгоор үнэлэх, нийт нутаг дэвсгэрийн болон тодорхой нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг харьцуулан судлах, давтамж, эрсдлийг тооцон, цаашдын хандлага болон урьдчилан сэргийлэх оновчтой арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлоход хамгийн ач холбогдолтой мэдээлэл болдог билээ.

Гэмт хэрэг, захиргааны зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаар бодитой мэдээллийг цаг алдалгүй бүрдүүлж буй мэдээлэл, судалгааны ажил хариуцсан алба хаагч болон цагдаагийн төрөл мэргэжлийн албадын шат шатны дарга, алба хаагч Та бүхэнд Мэдээлэл, технологийн төвөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааны чиглэлийг бүх талаар дэмжиж хамтран ажилласанд талархал илэрхийлж байна.

Энэхүү товхимолд орсон мэдээ, статистикийн дэлгэрэнгүй болон бусад шаардлагатай мэдээллийг цагдаагийн байгууллагын цахим хуудас / police.gov.mn/-аас авах боломжтой юм.

“Монгол Улсад 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал” товхимолын болон статистик үзүүлэлт, судалгааны талаар мэдээллийг сонирхсон хэн боловч өөрийн санал, хүсэлтээ манай хаягаар ирүүлбэл бид хүлээн авч хамтран ажиллах болно.

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ТӨВИЙН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Х. ЭНХЖАРГАЛ

НЭГ.МОНГОЛ УЛСАД 2015 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

§1. УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

1.1 Нийт 475434 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:

Гэмт хэргийн шинжтэй — 96661 буюу 20.3%

- ✓ 30439 буюу 31.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- ✓ 65885 буюу 68.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — 115236 буюу 24.2%

- ✓ 20.2 хувийг торгуулийн хуудсаар,
- ✓ 60.6 хувийг шийтгэврээр тус тус торгох
- ✓ 7.2 хувийг баривчлах,
- ✓ 10.6 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан,
- ✓ 0.3 хувийг нэгтгэж,
- ✓ 1.1 хувьд нь зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэл тогтоогдсон.

Дуудлага, мэдээлэл — 258735 буюу 54.5%

- ✓ зөвлөгөө өгсөн
- ✓ газар дээр нь зохицуулсан
- ✓ саатуулсан
- ✓ дуудлага худлаа байсан
- ✓ харьяаллаар шилжүүлэх байдлаар шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 4802 буюу 1.0 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хянан шийдвэрлэвэл зохих хуулийн хугацаанд байв.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй 96661 гомдол мэдээллийн 47.1 хувийг 5 хоногт, 52.8 хувийг 6-19 хоногт, 0.1 хувийг 20 түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй 115236 гомдол мэдээллийн 96.7 хувийг 14 хоногт, 3.2 хувийг 15-28 хоногт, 0.1 хувийг 29 буюу түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.



Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Улсын хэмжээнд 27757 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 439 хэргээр буюу 1.6 хувиар өссөн.

2.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /нутаг дэвсгэрээр/:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2014	2015		2014	2015
Орон нутагт	10093	9779	-3.1	36.9	35.2
Улаанбаатар хотод	17205	17939	4.3	63.0	64.7
Бусад газарт	20	39	95.0	0.1	0.1

2.3 Гэмт хэргийн гаралт буурсан, өссөн үзүүлэлт /нутаг дэвсгэрээр/:





2.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 3.3 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 1.5 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 8.6 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 2.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.5 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн төрлөөр/:

Хүнийг санаатай алах гэмт хэрэг 204, бусдын эд хөрөнгийг булаах 216, хүчиндэх 279, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх 333, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 537, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 1394, танхайрах 1582, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах 2067, бусдын бие махбодид гэмтэл учруулах 8064, бусдын эд хөрөнгийг хулгайлах 9169, бусад төрлийн гэмт хэрэг 3912 байна.

2.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•4655	16.8%
Мягмар	•4266	15.4%
Лхагва	•4159	14.9%
Пүрэв	•4127	14.9%
Баасан	•4028	14.5%
Бямба	•3328	12.0%
Ням	•3194	11.5%

32.2



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 88 буюу 2.1 хувиар, Лхагвад 44 буюу 1.1 хувиар, Пүрэвт 190 буюу 4.8 хувиар, Бямбад 136 буюу 4.3 хувиар, Ням гарагт 46 буюу 1.5 хувиар тус тус өсч, Баасанд 65 буюу 1.60 хувиар буурч, Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг өмнөх оны түвшинд байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 298 буюу 5.2 хувиар, 14-19 цагийн хооронд 622 буюу 8.5 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 108 буюу 2.4 хувиар, 22-06 цагийн хооронд 373 буюу 3.8 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

Улсын хэмжээнд 62.1 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.5 нэгжээр, Улаанбаатар хотод 58.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.5 нэгжээр тус тус өссөн байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 13922 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10.6 хувиар,

-үүнээс 8644 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 17.3 хувиар тус тус өссөн байна.

3.1 Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 5278 гэмт хэргийн төрөл:



Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 24857 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өссөн байна. Үүнээс 3782 буюу 15.2 хувь нь эмэгтэй, 21075 буюу 84.8 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд, тэдний 1402 буюу 5.6 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.2 хувиар тус тус өссөн байна.

-Гадаадын 92 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.7 хувиар өссөн байна.

4.1 Нас, нийгмийн байдал:





Тав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 113 аж ахуйн нэгж, байгууллага, 27948 иргэн хохирч, үүнээс 847 хүн нас барж, 11287 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 231 буюу 21.4 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 6 буюу 0.1 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 144.3 тэрбум төгрөгийн хохирлын 33.9 хувийг нөхөн төлүүлж, 38.9 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



Зургаа. Захиргааны зөрчил

6.1 Шалгасан захиргааны зөрчил:

Нийт 1423088 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 741866 буюу 2.0 дахин өссөн үзүүлэлттэй байна.

- Зөрчил гаргасан 1372058 иргэн, 37 албан тушаалтан, 1172 аж ахуйн нэгж, байгууллагад 17.0 тэрбум төгрөгөөр торгох,
- 26166 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах,
- 1 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, баривчлах
- 10440 хүнд торгож, эрх хасах,
- 13174 хүнд баривчлах,
- 40 хүнд торгож, баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

6.2 Захиргааны зөрчлийг нутаг дэвсгэрээр нь авч үзвэл:

Улаанбаатар хотод 1151800 буюу 80.9 хувь нь, орон нутагт 271288 буюу 19.1 хувь нь бүртгэгджээ.

6.3 Шийтгэл ногдуулсан албан тушаалтан:

Хуулийн нэр	Тоо	Хувь	Хуулийн нэр	Тоо	Хувь
Захиргааны хариуцлагын тухай	1193909	83.9	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай	520	0.04
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	222171	15.6	Галт зэвсгийн тухай	280	0.02
Тамхины хяналтын тухай	2247	0.16	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	170	0.01
Архидан согтуурахтай тэмцэх тухай	2082	0.15	Садар самуун явдалтай тэмцэх тухай	44	0.01
Жолоочийн даатгалын тухай	1054	0.07	Бусад хуулиар	655	0.05



2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-д заасан үндэслэлээр 211655 иргэн, 22 хуулийн этгээдийг 12.2 тэрбум төгрөгөөр торгох, зөрчлийн шинж байдлыг нь харгалзан торгох, эрх хасах шийтгэлийг 10481 иргэнд тус тус ногдуулсан байна.

6.5 Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Гараг	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2014	2015	
Даваа	112173	236400	2.1 дахин
Мягмар	110505	242652	2.2 дахин
Лхагва	107221	236179	2.2 дахин
Пүрэв	110427	221927	2.0 дахин
Баасан	90509	214387	2.4 дахин
Бямба	68552	131636	92.0%
Ням	81835	139907	71.0%



Зөрчил үйлдэгдсэн цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 06-12 цагийн хооронд 333226 буюу 3.1 дахин, 13-18 цагийн хооронд 325915 буюу 2.4 дахин, 19-00 цагийн хооронд 77527 буюу 31.1 хувиар, 01-05 цагийн хооронд 5198 буюу 13.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6.6 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан хүнийг саатуулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 97560 хүн эрүүлжүүлэгдсэнээс 59042 буюу 60.5 хувь нь Улаанбаатар хотод, 38518 буюу 39.5 хувь нь орон нутгийн цагдаагийн байгууллагад тус тус саатуулагдаж, үйлчилгээний төлбөрт 313.4 сая төгрөгийг төлсөн байна.

Өөрөөр хэлбэл хоногт дунджаар 267, үүнээс Улаанбаатар хотод 161, аймгуудад 106 хүн саатуулагджээ.



Саатуулагдсан хүмүүсийн 5442 буюу 5.6 хувь нь эмэгтэй, 387 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны, 117 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн байгаа ба архины албадан эмчилгээнд 339, сайн дурын эмчилгээнд 503 хүнийг тус тус хамруулжээ.

Тэдгээрийн 1926 буюу 2.0 хувь нь хөнгөн, 92638 буюу 95.0 хувь нь дунд, 2996 буюу 3.0 хувь нь хүнд зэргийн согтолттой, 57697 буюу 59.1 хувь нь гэр, орон сууц, 29350 буюу 30.1 хувь нь гудамж талбай, 3445 буюу 3.5 хувь нь байгууллага, аж ахуйн нэгж, 3070 буюу 3.1 хувь нь баар, цэнгээний газар, 1359 буюу 1.4 хувь нь зочид буудал, 413 буюу 0.4 хувь нь үзвэр, үйлчилгээний газар, 2226 буюу 2.3 хувь нь бусад газраас тус тус саатуулагдсан байна.

Саатуулагдсан хүмүүсийн 76128 буюу 78.0 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 10245 буюу 10.5 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 628 буюу 0.6 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, 9105 буюу 9.3 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 1356 буюу 1.4 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, 98 буюу 0.1 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасны улмаас тус тус саатуулагджээ.

ooOoo

§2. УЛААНБААТАР ХОТОД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧИЛ

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

1.1 Нийт 324367 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:

Гэмт хэргийн шинжтэй — 61938 буюу 19.1%

- ✓ 18313 буюу 29.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- ✓ 43547 буюу 70.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — 24354 буюу 7.5%

- ✓ 51.3 хувийг торгуулийн хуудсаар,
- ✓ 32.9 хувийг шийтгэврээр тус тус торгох
- ✓ 10.3 хувийг баривчлах,
- ✓ 4.3 хувийг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан,
- ✓ 0.1 хувийг нэгтгэж,
- ✓ 1.1 хувьд нь зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэл тогтоогдсон.

Дуудлага, мэдээлэл — 234775 буюу 72.4%

- ✓ зөвлөгөө өгсөн
- ✓ газар дээр нь зохицуулсан
- ✓ саатуулсан
- ✓ дуудлага худлаа байсан
- ✓ харьяаллаар шилжүүлэх байдлаар шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 3300 буюу 1.0 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу буюу хянан шийдвэрлэвэл зохих хуулийн хугацаанд байв.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй 61938 гомдол мэдээллийн 42.71 хувийг 5 хоногт, 57.26 хувийг 6-19 хоногт, 0.03 хувийг 20 түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй 24354 гомдол мэдээллийн 93.9 хувийг 14 хоногт, 6.0 хувийг 15-28 хоногт, 0.1 хувийг 29 буюу түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.



Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Улаанбаатар хотын хэмжээнд 17939 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 734 хэргээр буюу 4.3 хувиар өссөн.

2.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /нутаг дэвсгэрээр/:

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийслэлд бүртгэгдсэн хэрэгт эзлэх хувь	
	2014	2015		2014	2015
Баянгол	2813	2951	4.9	16.3	16.5
Баянзүрх	4267	4272	0.1	24.8	23.8
Сонгинохайрхан	3042	3232	6.2	17.7	18.0
Сүхбаатар	2594	3085	18.9	15.1	17.2
Хан-Уул	1496	1390	-7.1	8.7	7.7
Чингэлтэй	2393	2254	-5.8	13.9	12.6
Багануур	236	311	31.8	1.4	1.7
Багахангай	25	21	-16.0	0.1	0.1
Налайх	339	423	24.8	2.0	2.4

2.3 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

- хөнгөн гэмт хэрэг 6.1 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 5.4 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 12.8 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 3.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.4 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн төрлөөр/:

Хүнийг санаатай алах гэмт хэрэг 113, хүчиндэх 133, бусдын эд хөрөнгийг булаах 183, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх 201, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх 446, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих 623, танхайрах 1253, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах 1788, бусдын бие махбодид гэмтэл учруулах 4784, бусдын эд хөрөнгийг хулгайлах 5899, бусад төрлийн гэмт хэрэг 2516 байна.



2.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•3164	17.6%
Мягмар	•2844	15.9%
Лхагва	•2719	15.2%
Пүрэв	•2698	15.0%
Баасан	•2592	14.4%
Бямба	•2042	11.4%
Ням	•1880	10.5%

33.5



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 59 буюу 1.9 хувиар, Мягмарт 173 буюу 6.5 хувиар, Лхагвад 101 буюу 3.9 хувиар, Пүрэвт 181 буюу 7.2 хувиар, Баасанд 22 буюу 0.90 хувиар, Бямбад 133 буюу 7.0 хувиар, Нямд 65 буюу 3.6 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 246 буюу 6.1 хувиар, 14-19 цагийн хооронд 694 буюу 14.7 хувиар, 19-22 цагийн хооронд 21 буюу 0.8 хувиар тус тус өсч, 22-06 цагийн хооронд 227 буюу 3.9 хувиар буурсан байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

Улаанбаатар хотод 58.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 3.5 нэгжээр өссөн байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 10130 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12.1 хувиар,

-үүнээс 5966 гэмт хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 19.2 хувиар тус тус өссөн байна.



3.1 Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй 4164 гэмт хэргийн төрөл:



Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

Улаанбаатар хотод нийт 14511 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.5 хувиар өссөн байна. Үүнээс 2576 буюу 17.8 хувь нь эмэгтэй, 11935 буюу 82.2 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд, 5.3 хувь буюу 775 нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.6 хувиар өссөн байна.

Гадаадын 68 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар өссөн байна.

4.1 Нас, нийгмийн байдал:



Тав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 52 аж ахуйн нэгж, байгууллага, 17550 иргэн хохирч, үүнээс 334 хүн нас барж, 6740 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 112 буюу 25.1 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 169 буюу 2.6 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 87.3 тэрбум төгрөгийн хохирлын 29.7 хувийг нөхөн төлүүлж, 28.9 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



Зургаа. Захиргааны зөрчил

6.1 Шалгасан захиргааны зөрчил:

Нийт 1151800 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 775486 буюу 3.1 дахин өсчээ.

-Зөрчил гаргасан 1120347 иргэн, 16 албан тушаалтан, 981 аж ахуйн нэгж, байгууллагад 14.0 тэрбум төгрөгөөр торгох,

-17106 хүнд тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах,

-1 хүнд тээврийн хэрэгсэл хасаж, баривчилах

-6928 хүнд торгож, эрх хасах,

-6420 хүнд баривчлах,

- 1 хүнд торгож, баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

-Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон Улсын хэмжээнд 97560 хүн саатуулагдсанаас 59042 буюу 60.5 хувь нь Улаанбаатарт, тэдний 3470 буюу 5.9 хувь нь эмэгтэй, 209 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байх ба 325 хүнийг архины албадан, 238 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

6.2 Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэсэн цагдаагийн газар, хэлтсээр харуулбал:

	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийслэлд бүртгэгдсэн зөрчилд эзлэх хувь	
	2014	2015		2014	2015
Баянгол	19643	22068	12.3	1.7	1.9
Баянзүрх	26182	37507	43.3	2.3	3.3
Сонгинохайрхан	42980	38034	-11.5	3.7	3.3
Сүхбаатар	25724	30232	17.5	2.2	2.6
Хан-Уул	14013	15000	7.0	1.2	1.3
Чингэлтэй	14566	15957	9.5	1.3	1.4
Багануур	12717	18571	46.0	1.1	1.6
Багахангай	2820	9076	3.2 дахин	0.2	0.8
Налайх	10212	28509	3.0 дахин	0.9	2.5
Замын цагдаагийн газар	195445	865544	4.4 дахин	17.0	75.1
Олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба	563	44786	79.5 дахин	0.05	3.9
Улаанбаатар хотын цагдаагийн газар	693	2148	3.1 дахин	0.1	0.2
Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс	512	2504	5.0 дахин	0.04	0.2
Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс	10196	21864	2.1 дахин	0.9	1.9

6.3 Шийтгэл ногдуулсан албан тушаалтан: 1144945 буюу 99.4 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 6855 буюу 0.6 хувьд шүүгч шийтгэл ногдуулсан байна.

6.4 Захиргааны зөрчил / шийтгэл ногдуулсан хуулиар:

Хуулийн нэр	Тоо	Хувь	Хуулийн нэр	Тоо	Хувь
Захиргааны хариуцлагын тухай	957354	83.9	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай	21	0.04
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	190069	15.6	Галт зэвсгийн тухай	103	0.02
Тамхины хяналтын тухай	1697	0.16	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	125	0.01
Архидан согтуурахтай тэмцэх тухай	1188	0.15	Садар самуун явдалтай тэмцэх тухай	38	0.01
Жолоочийн даатгалын тухай	836	0.07	Бусад хуулиар	369	0.05

2015 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-д заасан үндэслэлээр 211655 иргэн, 21 хуулийн этгээдийг 9.5 тэрбум төгрөгөөр торгох, зөрчлийн шинж байдлыг нь харгалзан торгож, эрх хасах, шийтгэлийг 6930 иргэнд тус тус ногдуулсан байна.



6.5 Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Гараг	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2014	2015	
Даваа	62078	191996	3.1 дахин
Мягмар	60669	199240	3.3 дахин
Лхагва	57646	192579	3.3 дахин
Пүрэв	62588	180578	3.6 дахин
Баасан	48753	175231	3.6 дахин
Бямба	37611	103956	2.8 дахин
Ням	46969	108220	2.3 дахин



Зөрчил үйлдэгдсэн цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 06-12 цагийн хооронд 342006 буюу 4.2 дахин, 13-18 цагийн хооронд 338165 буюу 3.6 дахин, 19-00 цагийн хооронд 90191 буюу 81.9 хувиар, 01-05 цагийн хооронд 5124 буюу 16.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6.6 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан хүнийг саатуулах үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн 59042 хүнийг саатуулж, үйлчилгээний төлбөрт 174.2 сая төгрөгийг төлүүлсэн байна. Хоногт дунджаар 161 хүн саатуулагджээ.

Саатуулагдсан хүмүүсийн 3470 буюу 5.9 хувь нь эмэгтэй, 209 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны, 75 буюу 0.1 хувь нь гадаадын иргэн, харьяалалгүй хүн байгаа ба архины албадан эмчилгээнд 325, сайн дурын эмчилгээнд 238 хүнийг тус тус хамруулав.

Тэдгээрийн 251 буюу 0.4 хувь нь хөнгөн, 58543 буюу 99.2 хувь нь дунд, 248 буюу 0.4 хувь нь хүнд зэргийн согтолттой, 35291 буюу 59.8 хувь нь гэр, орон сууц, 16944 буюу 28.7 хувь нь гудамж талбай, 2170 буюу 3.7 хувь нь байгууллага, аж ахуйн нэгж, 2018 буюу 3.4 хувь нь баар, цэнгээний газар, 785 буюу 1.3 хувь нь зочид буудал, 120 буюу 0.2 хувь нь үзвэр, үйлчилгээний газар, 1714 буюу 2.9 хувь нь бусад газраас тус тус саатуулагджээ.

Саатуулагдсан иргэдийн 46187 буюу 73.9 хувь нь бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, 6540 буюу 11.1 хувь нь гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 484 буюу 0.8 хувь нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсний улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, 5460 буюу 9.2 хувь нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, 338 буюу 0.6 хувь нь гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй, 33 буюу 0.1 хувь нь гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасны улмаас тус тус саатуулагджээ.

ooOoo

§2.1. Баянгол дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

1.1 Нийт 50553 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:

Гэмт хэргийн шинжтэй — 12011 буюу 23.8%

- ✓ 2915 буюу 24.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- ✓ 9096 буюу 75.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — 2092 буюу 4.1%

- ✓ 16.0 хувийг торгуулийн хуудсаар,
- ✓ 76.2 хувийг шийтгэврээр тус тус торгох
- ✓ 2.9 хувийг баривчлах,
- ✓ 4.9 хувьд нь зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэл тогтоогдсон.

Дуудлага, мэдээлэл — 35687 буюу 70.6%

- ✓ зөвлөгөө өгсөн
- ✓ газар дээр нь зохицуулсан
- ✓ саатуулсан
- ✓ дуудлага худлаа байсан
- ✓ харьяаллаар шилжүүлэх байдлаар шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 763 буюу 1.5 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хянан шийдвэрлэвэл зохих хуулийн хугацаанд байв.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй 12011 гомдол мэдээллийн 27.8 хувийг 5 хоногт, 72.1 хувийг 6-19 хоногт, 0.1 хувийг 20 түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй 2092 гомдол мэдээллийн 87.7 хувийг 14 хоногт, 12.1 хувийг 15-28 хоногт, 0.2 хувийг 29 ба түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

-2951 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 138 хэргээр буюу 4.9 хувиар өссөн байна.

2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 11.0 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 0.7 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 0.6 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 31.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.3 Нийт бүртгэгдсэн 2951 гэмт хэргийн бүтэц /хэргийн төрлөөр/:

- 11 буюу 0.37 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх,
- 13 буюу 0.4 хувийг хүнийг санаатай алах,
- 20 буюу 0.7 хувийг хүчиндэх,
- 38 буюу 1.3 хувийг булаах
- 46 буюу 1.6 хувийг завших, үрэгдүүлэх
- 74 буюу 2.5 хувийг дээрэмдэх,
- 76 буюу 2.6 хувийг зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй зугтаах,
- 100 буюу 3.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 240 буюу 8.1 хувийг танхайрах,
- 418 буюу 14.2 хувийг залилан мэхлэх,
- 670 буюу 22.7 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 913 буюу 30.9 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 332 буюу 11.23 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

Даваа	•563	19.1%
Мягмар	•481	16.3%
Лхагва	•462	15.6%
Пүрэв	•464	15.7%
Баасан	•393	13.3%
Бямба	•304	10.4%
Ням	•284	9.6%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 18 буюу 3.9 хувиар, Лхагвад 42 буюу 10.0 хувиар, Пүрэвт 41 буюу 9.7 хувиар, Бямбад 100 буюу 49.0 хувиар тус тус өсч, Баасан гарагт 27 буюу 6.4 хувиар, Нямд 15 буюу 5.0 хувиар тус тус буурсан байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 79 буюу 7.9 хувиар өсч, 06-14 цагийн хооронд 99 буюу 16.4 хувиар, 14-19 цагийн хооронд 69 буюу 10.0 хувиар, 19-22 цагийн хооронд 49 буюу 9.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Нийтийн тээвэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 14 буюу 31.1 хувиар, төрийн бус байгууллагад 29 буюу 80.6 хувиар, гудамж талбайд 30 буюу 4.0 хувиар, гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 60 буюу 9.8 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 73 буюу 21.0 хувиар тус тус өсч, олон нийтийн газарт 22 буюу 3.4 хувиар, авто замд 13 буюу 6.7 хувиар, төрийн байгууллагад 4 буюу 13.3 хувиар, бусад газарт 29 буюу 19.7 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 1212 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7.5 хувиар,

- түүнээс 813 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн,
- илрүүлэлт 67.1 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 3.3 нэгжээр өссөн байна.



Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 2488 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувиар өссөн байна. Үүнээс 499 буюу 20.0 хувь нь эмэгтэй, 1989 буюу 80.0 хувь нь эрэгтэй, тэдний 113 буюу 4.5 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 7.1 хувиар, эрэгтэй 9.5 хувиар тус тус өсч, хүүхэд 13.7 хувиар буурсан байна.

Гадаадын 10 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.0 хувиар өссөн байна.

4.1 Нас, нийгмийн байдал:



Тав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 2 аж ахуйн нэгж, байгууллага, 2916 иргэн хохирч, үүнээс 45 хүн нас барж, 1334 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 19 буюу 29.7 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 100 буюу 8.1 хувиар өссөн байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 14.8 тэрбум төгрөгийн хохирлын 36.3 хувийг нөхөн төлүүлж, 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



Зургаа. Захиргааны зөрчил

6.1 Шалгасан захиргааны зөрчил:

Нийт 22068 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2425 буюу 12.3 хувиар өсчээ.

- Зөрчил гаргасан 21605 иргэн, 3 албан тушаалтан, 350 аж ахуйн нэгж, байгууллагад 221.2 сая төгрөгөөр торгох,
- 110 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан байна.
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 6955 хүн саатуулагдсаны 3 буюу 0.04 хувь нь эмэгтэй, 29 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

6.2 Шийтгэл ногдуулсан албан тушаалтан: 21951 буюу 99.5 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 117 буюу 0.5 хувьд шүүгч шийтгэл ногдуулсан байна.

6.3 Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Гараг	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2014	2015	
Даваа	3046	3492	14.6
Мягмар	3115	3626	16.4
Лхагва	3466	3627	4.6
Пүрэв	3035	3383	11.5
Баасан	2790	3193	14.4
Бямба	2194	2428	10.7
Ням	1997	2319	16.1



Зөрчил үйлдэгдсэн цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 06-12 цагийн хооронд 1005 буюу 34.5 хувиар, 13-18 цагийн хооронд 2421 буюу 33.4 хувиар тус тус өсч, 19-24 цагийн хооронд 842 буюу 11.1 хувиар, 01-05 цагийн хооронд 159 буюу 8.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

§2.2. Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

1.1 Нийт 82982 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:

Гэмт хэргийн шинжтэй — 17994 буюу 21.7%
- ✓ 4379 буюу 24.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- ✓ 13610 буюу 75.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — 2612 буюу 3.1%
- ✓ 11.8 хувийг торгуулийн хуудсаар,
- ✓ 71.4 хувийг шийтгэврээр тус тус торгох
- ✓ 14.8 хувийг баривчлах,
- ✓ 2.0 хувьд нь зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэл тогтоогдсон.

Дуудлага, мэдээлэл — 61735 буюу 74.4%
- ✓ зөвлөгөө өгсөн
- ✓ газар дээр нь зохицуулсан
- ✓ саатуулсан
- ✓ дуудлага худлаа байсан
- ✓ харьяаллаар шилжүүлэх байдлаар шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 641 буюу 0.8 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хянан шийдвэрлэвэл зохих хуулийн хугацаанд байв.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй 17994 гомдол мэдээллийн 50.7 хувийг 5 хоногт, 49.3 хувийг 6-19 хоногт, 0.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй 2612 гомдол мэдээллийн 90.5 хувийг 14 хоногт, 9.5 хувийг 15-28 хоногт тус тус шийдвэрлэсэн байна.

Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

-4272 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хэргээр буюу 0.1 хувиар өссөн байна.

2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хүндэвтэр гэмт хэрэг 7.6 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 12.9 хувиар тус тус өсч,
- хөнгөн гэмт хэрэг 3.8 хувиар,
- хүнд гэмт хэрэг 20.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.3 Нийт бүртгэгдсэн 4272 гэмт хэргийн бүтэц /хэргийн төрлөөр/:

- 29 буюу 0.7 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх,
- 32 буюу 0.7 хувийг хүнийг санаатай алах,
- 36 буюу 0.8 хувийг хүчиндэх,
- 42 буюу 1.0 хувийг завших, үрэгдүүлэх
- 49 буюу 1.1 хувийг булаах,
- 126 буюу 2.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 141 буюу 3.3 хувийг дээрэмдэх,
- 343 буюу 8.0 хувийг танхайрах,
- 353 буюу 8.3 хувийг залилан мэхлэх,
- 1096 буюу 25.7 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 1532 буюу 35.9 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 493 буюу 11.6 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

2.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	667	15.6%
Мягмар	651	15.2%
Лхагва	637	14.9%
Пүрэв	644	15.1%
Баасан	622	14.6%
Бямба	524	12.3%
Ням	527	12.3%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Мягмар гарагт үйлдэгдсэн хэрэг 18 буюу 2.8 хувиар, Лхагвад 1 буюу 0.2 хувиар, Пүрэвт 61 буюу 10.5 хувиар, Баасанд 4 буюу 0.6 хувиар тус тус өсч, Даваа гарагт 22 буюу 3.2 хувиар, Бямбад 49 буюу 8.6 хувиар, Нямд 8 буюу 1.5 хувиар тус тус буурсан байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 129 буюу 16.2 хувиар, 14-19 цагийн хооронд 72 буюу 5.7 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 39 буюу 6.4 хувиар, 22-06 цагийн хооронд 157 буюу 9.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 7 буюу 17.5 хувиар, байгууллагад 26 буюу 7.2 хувиар, гэр орон сууцанд 166 буюу 12.7 хувиар, аж ахуйн нэгж, бусад газарт 43 буюу 19.1 хувиар тус тус өсч, гудамж талбайд 142 буюу 11.8 хувиар, олон нийтийн газарт 44 буюу 5.4 хувиар, нийтийн тээвэрт 21 буюу 41.2 хувиар, төрийн бус байгууллагад 8 буюу 18.2 хувиар, авто замд 22 буюу 10.0 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 2604 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.7 хувиар буурч,

- түүнээс 1400 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн,
- илрүүлэлт 53.8 хувьтай байгаа нь өмнөх оныхоос 5.5 нэгжээр өссөн байна.



Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

Гэмт хэрэгт 3216 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувиар өссөн. Үүнээс 574 буюу 17.8 хувь нь эмэгтэй, 2642 буюу 82.2 хувь нь эрэгтэй, 169 буюу 5.2 хувь нь хүүхэд байх ба өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 8.7 хувиар, эрэгтэй 10.9 хувиар, хүүхэд 70.7 хувиар тус тус өссөн байна.

4.1 Нас, нийгмийн байдал:



Тав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 16 байгууллага, 4236 иргэн хохирч, үүнээс 91 хүн нас барж, 1614 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 13 буюу 12.5 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 24 буюу 1.5 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 11.9 тэрбум төгрөгийн хохирлын 30.4 хувийг нөхөн төлүүлж, 3.6 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



Зургаа. Захиргааны зөрчил

6.1 Шалгасан захиргааны зөрчил:

Нийт 37507 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11325 буюу 43.3 хувиар өсчээ.

- Зөрчил гаргасан 36739 иргэн, 138 аж ахуйн нэгж, байгууллагад 255.7 сая төгрөгөөр торгох,
- 630 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 13135 хүн саатуулагдсанаас 31 буюу 0.2 хувь нь эмэгтэй, 49 буюу 0.4 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байх ба 62 хүнийг албадан, 41 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан байна.

6.2 Шийтгэл ногдуулсан албан тушаалтан: 36820 буюу 98.2 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 687 буюу 1.8 хувьд шүүгч шийтгэл ногдуулсан байна.

6.3. Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Гараг	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2014	2015	
Даваа	3815	5538	45.2
Мягмар	3722	5315	42.8
Лхагва	4306	5959	38.4
Пүрэв	4275	5843	36.7
Баасан	3755	5411	44.1
Бямба	3362	4440	32.1
Ням	2947	5001	69.7



Зөрчил үйлдэгдсэн цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 06-12 цагийн хооронд 2975 буюу 74.4 хувиар, 13-18 цагийн хооронд 3363 буюу 36.1 хувиар, 19-00 цагийн хооронд 3298 буюу 31.7 хувиар, 01-05 цагийн хооронд 1689 буюу 68.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

§2.3. Сүхбаатар дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

1.1 Нийт 28148 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:

Гэмт хэргийн шинжтэй — 9002 буюу 32.0%

- ✓ 3243 буюу 36.0 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- ✓ 5737 буюу 63.7 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — 5790 буюу 20.6%

- ✓ 79.6 хувийг торгуулийн хуудсаар,
- ✓ 14.0 хувийг шийтгэврээр тус тус торгох
- ✓ 5.9 хувийг баривчлах,
- ✓ 0.5 хувьд нь зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэл тогтоогдсон.

Дуудлага, мэдээлэл — 12755 буюу 45.3%

- ✓ зөвлөгөө өгсөн
- ✓ газар дээр нь зохицуулсан
- ✓ саатуулсан
- ✓ дуудлага худлаа байсан
- ✓ харьяаллаар шилжүүлэх байдлаар

шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 601 буюу 2.1 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хянан шийдвэрлэвэл зохих хуулийн хугацаанд байв.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй 9002 гомдол, мэдээллийн 41.6 хувийг 5 хоногт, 58.3 хувийг 6-19 хоногт, 0.1 хувийг 20 ба түүнээс дээш хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй 5790 гомдол, мэдээллийн 89.1 хувийг 14 хоногт, 10.8 хувийг 15-28 хоногт, 0.1 хувийг 29 ба түүнээс дээш хоногт тус тус шийдвэрлэсэн байна.





Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

-3085 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 491 хэргээр буюу 18.9 хувиар өссөн байна.

2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 18.9 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 23.2 хувиар,
- хүнд гэмт хэрэг 3.4 хувиар тус тус өсч,
- онц хүнд гэмт хэрэг мөн үеийн түвшинд байна.

2.3 Нийт бүртгэгдсэн 3085 гэмт хэргийн бүтэц /хэргийн төрлөөр/:

- 2 буюу 0.1 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх,
- 11 буюу 0.4 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх,
- 12 буюу 0.4 хувийг хүчиндэх,
- 13 буюу 0.4 хувийг хүнийг санаатай алах,
- 35 буюу 1.1 хувийг завших, үрэгдүүлэх
- 37 буюу 1.2 хувийг бусдын эд хөрөнгийг булаах,
- 69 буюу 2.2 хувийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх
- 82 буюу 2.7 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 197 буюу 6.3 хувийг танхайрах,
- 409 буюу 13.3 хувийг залилан мэхлэх,
- 666 буюу 21.6 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 1171 буюу 37.9 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 381 буюу 12.4 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

2.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•513	16.6%	31.6
Мягмар	•461	14.9%	
Лхагва	•464	15.1%	
Пүрэв	•473	15.3%	
Баасан	•469	15.2%	
Бямба	•375	12.2%	
Ням	•330	10.7%	



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 120 буюу 30.5 хувиар, Мягмарт 92 буюу 24.9 хувиар, Лхагвад 90 буюу 24.1 хувиар, Пүрэвт 90 буюу 23.5 хувиар, Баасанд 39 буюу 9.1 хувиар, Бямбад 17 буюу 4.7 хувиар, Нямд 43 буюу 15.0 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 97 буюу 14.8 хувиар, 14-19 цагийн хооронд 236 буюу 28.4 хувиар, 19-22 цагийн хооронд 85 буюу 25.1 хувиар, 22-06 цагийн хооронд 73 буюу 9.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2.7 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 190 буюу 35.1 хувиар, аж ахуйн нэгжид 155 буюу 30.4 хувиар, гудамж талбайд 109 буюу 21.7 хувиар, нийтийн тээвэр 35 буюу 49.3 хувиар, төрийн байгууллагад 29 буюу 82.9 хувиар, олон нийтийн газарт 2 буюу 0.4 хувиар тус тус өсч, бусад газарт 18 буюу 8.7 хувиар, авто замд 11 буюу 7.1 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 1961 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 55.8 хувиар өсч,

- түүнээс 1118 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн,
- илрүүлэлт 57.0 хувьтай байгаа нь 1.8 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.



Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 2417 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.2 хувиар өссөн байна. Үүнээс 460 буюу 19.0 хувь нь эмэгтэй, 1957 буюу 81.0 хувь нь эрэгтэй, тэдний 157 буюу 6.5 хувь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 31.1 хувиар, эрэгтэй 19.0 хувиар, хүүхэд 84.7 хувиар тус тус өссөн байна.

Гадаадын 20 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 53.8 хувиар өссөн байна.

4.1 Нас, нийгмийн байдал:



Тав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 10 аж ахуйн нэгж, байгууллага, 3015 иргэн хохирч, үүнээс 37 хүн нас барж, 850 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 16 буюу 30.2 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 195 буюу 29.8 хувиар өссөн байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 19.2 тэрбум төгрөгийн хохирлын 24.7 хувийг нөхөн төлүүлж, 2.8 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



Зургаа. Захиргааны зөрчил

6.1 Бүртгэгдсэн захиргааны зөрчил:

Нийт 30232 /давхардсан тоогоор/ захиргааны зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4508 буюу 17.5 хувиар өсчээ.

- Зөрчил гаргасан 29570 иргэн, 1 албан тушаалтан, 128 аж ахуйн нэгж, байгууллагад 196.5 сая төгрөгөөр торгох,
- 533 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан.
- Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 6813 хүн саатуулагдсанаас 11 буюу 0.2 хувь нь эмэгтэй, 39 буюу 0.6 хувийг 18 хүртэлх насны хүмүүс байна.

6.2 Шийтгэл ногдуулсан албан тушаалтан: 29641 буюу 98.0 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 591 буюу 2.0 хувьд шүүгч шийтгэл ногдуулсан байна.

6.3 Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Гараг	Зөрчлийн тоо		Өсөлт, бууралтын хувь
	2014	2015	
Даваа	3850	4560	18.4
Мягмар	4271	4972	16.4
Лхагва	4339	4996	15.1
Пүрэв	3962	4687	18.3
Баасан	3532	4511	27.7
Бямба	2982	3432	15.1
Ням	2788	3074	10.3



Зөрчил үйлдэгдсэн цагийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, 06-12 цагийн хооронд 2820 буюу 97.6 хувиар, 13-18 цагийн хооронд 973 буюу 11.1 хувиар, 19-24 цагийн хооронд 438 буюу 4.0 хувиар, 01-05 цагийн хооронд 277 буюу 9.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

§2.4. Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчил

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл

1.1 Нийт 72941 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас:

Гэмт хэргийн шинжтэй — 10167 буюу 13.9%

- ✓ 3280 буюу 32.3 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- ✓ 6877 буюу 67.6 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан.

Зөрчлийн шинжтэй — 2115 буюу 2.9%

- ✓ 14.0 хувийг торгуулийн хуудсаар,
- ✓ 60.9 хувийг шийтгэврээр тус тус торгох
- ✓ 23.6 хувийг баривчлах,
- ✓ 0.1 хувийг нэгтгэн шалгасан,
- ✓ 1.4 хувьд нь зөрчлийг хянан шалгах ажиллагаа явуулж болохгүй үндэслэл тогтоогдсон.

Дуудлага, мэдээлэл — 60216 буюу 82.6%

- ✓ зөвлөгөө өгсөн
- ✓ газар дээр нь зохицуулсан
- ✓ саатуулсан
- ✓ дуудлага худлаа байсан
- ✓ харьяаллаар шилжүүлэх байдлаар шийдвэрлэсэн байна.

Гомдол мэдээллийн 443 буюу 0.6 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хянан шийдвэрлэвэл зохих хуулийн хугацаанд байв.

1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар харуулбал:

Гэмт хэргийн шинжтэй 10167 гомдол, мэдээллийн 50.8 хувийг 5 хоногт, 49.2 хувийг 6-19 хоногт, захиргааны зөрчлийн шинжтэй 2115 гомдол, мэдээллийн 94.4 хувийг 14 хоногт, 5.6 хувийг 15-28 хоногт тус тус шийдвэрлэсэн байна.





Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

-3232 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 190 хэргээр буюу 6.2 хувиар өссөн байна.

2.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 16.8 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 2.3 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 13.9 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 28.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2.3 Нийт бүртгэгдсэн 3232 гэмт хэргийн бүтэц /хэргийн төрлөөр/:

- 2 буюу 0.1 хувийг бусдыг болгоомжгүй алах,
- 19 буюу 0.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх,
- 21 буюу 0.6 хувийг хүнийг санаатай алах,
- 21 буюу 0.6 хувийг завших, үрэгдүүлэх
- 35 буюу 1.1 хувийг хүчиндэх,
- 35 буюу 1.1 хувийг бусдын эд хөрөнгийг булаах,
- 98 буюу 3.0 хувийг бусдын эд хөрөнгийг дээрэмдэх
- 143 буюу 4.4 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих,
- 158 буюу 5.0 хувийг залилан мэхлэх,
- 227 буюу 7.0 хувийг танхайрах,
- 825 буюу 25.5 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах,
- 1268 буюу 39.2 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах,
- 380 буюу 11.8 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

2.4. Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	724	22.4%
Мягмар	561	17.4%
Лхагва	489	15.1%
Пүрэв	457	14.1%
Баасан	482	14.9%
Бямба	264	8.2%
Ням	255	7.9%

(Даваа + Мягмар) → 39.8



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 52 буюу 7.7 хувиар, Мягмарт 41 буюу 7.9 хувиар, Баасанд 66 буюу 15.9 хувиар, Бямбад 29 буюу 12.3 хувиар, Нямд 8 буюу 3.2 хувиар тус тус өсч, Лхагва гарагт 4 буюу 0.8 хувиар, Пүрэвт 2 буюу 0.4 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 14-19 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 253 буюу 37.8 хувиар 22-06 цагийн хооронд 68 буюу 7.1 хувиар өсч, 06-14 цагийн хооронд 111 буюу 12.1 хувиар, 19-22 цагийн хооронд 20 буюу 4.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2.7 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 195 буюу 16.0 хувиар, авто замд 65 буюу 31.7 хувиар, бусад газарт 53 буюу 22.7 хувиар, аж ахуйн нэгжид 24 буюу 10.3 хувиар, олон нийтийн газарт 14 буюу 5.0 хувиар тус тус өсч, гудамж талбайд 131 буюу 17.2 хувиар, төрийн байгууллагад 14 буюу 42.4 хувиар, төрийн бус байгууллагад 9 буюу 40.9 хувиар, нийтийн тээвэр 7 буюу 11.5 хувиар тус тус буурсан байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт

Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 2061 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 16.6 хувиар өсч,

- түүнээс 1235 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн,
- илрүүлэлт 59.9 хувьтай байгаа нь 1.4 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 2661 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9 хувиар өссөн байна. Үүнээс 388 буюу 14.6 хувь нь эмэгтэй, 2273 буюу 85.4 хувь нь эрэгтэй, тэдний 129 буюу 4.8 хувь нь хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 13.5 хувиар, эрэгтэй 8.1 хувиар, хүүхэд 27.7 хувиар тус тус өссөн байна.

Хэргийн 14.9 хувь нь хөнгөн, 66.0 хувь нь хүндэвтэр, 14.9 хувь нь хүнд, 4.3 хувь нь онц хүнд ангиллын хэрэг байгаа ба 10.6 хувь нь гэр, орон сууцанд, 14.9 хувь нь гудамж талбайд, 14.9 хувь нь олон нийтийн газарт, 8.5 хувь нь аж ахуйн нэгжид, 4.3 хувь нь тус бүр төрийн болон төрийн бус байгууллагад, 40.4 хувь нь бусад газарт, 14.9 хувь нь Даваад, 12.8 хувь нь Мягмарт, 6.4 хувь нь Лхагвад, 17.0 хувь нь Пүрэвт, 19.1 хувь нь Баасанд, 19.1 хувь нь Бямбад, 10.6 хувь нь Нямд, 14.9 хувь нь 06-14 цагт, 17.0 хувь нь 14-19 цагт, 12.8 хувь нь 19-22 цагт, 55.3 хувь нь 22-06 цагт тус тус бүртгэгджээ.

Энэ хэрэгт 102 хүн урьдчилан үгсэж тохиролцон оролцсон нь өмнөх оныхоос 25.9 хувиар өссөн байна.

§5.3. Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэг	39	38	- 1	- 2.6
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	0.1	0.1		

1.2 Гэмт хэргийн ангиллаар:

Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хүндэвтэр хэрэг 21.9 хувиар,
- хүнд хэрэг 2.3 дахин,
- онц хүнд хэрэг 3.0 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.



1.3 Галт зэвсгээр үйлдэгдсэн хэргийн бүтэц /гэмт хэргийн төрлөөр/:

Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 2.6 хувь, хүнийг санаатай алах хэрэг 5.3 хувь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх хэрэг 5.3 хувь, танхайрах хэрэг 13.2 хувь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 18.4 хувь, ан агнуурын хууль тогтоомж зөрчих хэрэг 44.7 хувь, бусад төрлийн хэрэг 10.5 хувийг тус тус эзэлж байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•5	13.2%
Мягмар	•4	10.5%
Лхагва	•5	13.2%
Пүрэв	•4	10.5%
Баасан	•2	5.3%
Бямба	•11	28.9%
Ням	•7	18.4%

47.3



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 3 буюу 37.5 хувиар, Мягмарт 2 буюу 33.3 хувиар, Лхагвад 1 буюу 16.7 хувиар, Баасанд 5 буюу 71.4 хувиар тус тус буурч, Пүрэвт 1 буюу 33.3 хувиар, Бямбад 9 буюу 5.5 дахин өсч, Нямд үйлдэгдсэн хэрэг өмнөх оны түвшинд байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 33.3 хувиар, 19-22 цагийн хооронд 2 буюу 33.3 хувиар, 22-06 цагийн хооронд 3 буюу 20.0 хувиар тус тус буурч, 14-19 цагийн хооронд 7 буюу 77.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 3 буюу 2.5 дахин өсч, гудамж талбайд 1 буюу 50.0 хувиар, бусад газарт 3 буюу 9.1 хувиар тус тус буурсан байна.

1.6 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:

Төв аймагт 6, Говь-Алтайд 5, Сүхбаатар, Хөвсгөлд 3, Дархан-Уул, Дорноговь, Баянхонгор, Ховдод тус бүр 2, Баян-Өлгий, Увс, Архангай, Булган, Өмнөговь, Сэлэнгэ, Хэнтий аймагт тус бүр 1, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэгт тус бүр 2, Баянзүрх дүүрэг, бусад газарт тус бүр 1 хэрэг тус тус бүртгэгджээ.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт Хөвсгөл аймагт 25.0 хувиар, Ховд, Дорноговьд тус бүр 33.3 хувиар, Булган, Архангай, Баян-Өлгий, Хэнтий аймагт тус бүр 50.0 хувиар тус тус буурч, Төв аймагт 20.0 хувиар, Говь-Алтайд 2.5 дахин, Сүхбаатар дүүрэгт 2.0 дахин тус тус өсч, Увс, Өмнөговь, Баянзүрх дүүрэгт өмнөх оны түвшинд байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Галт зэвсгээр үйлдэгдсэн гэмт хэрэгт 47 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны түвшинд байгаа ба нийт холбогдогчийн 1 буюу 2.1 хувь нь эмэгтэй, 46 буюу 97.9 хувь нь эрэгтэй, үүнээс 2 буюу 4.3 хувийг 14-17 насны хүүхэд эзэлж байна.

2.1. Нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 1 аж ахуйн нэгж, байгууллага, 25 иргэн хохирч, үүнээс 6 хүн нас барж, 3 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 5 буюу 6.0 дахин, гэмтсэн хүний тоо 2 буюу 3.0 дахин тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 206.7 сая төгрөгийн хохирлын 56.1 хувийг нөхөн төлүүлж, 31.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§5.4. Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Улсын хэмжээнд 2015 онд 27757 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 1356 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 280 хэргээр буюу 26.0 хувиар, бүх хэрэгт эзлэх хувийн жин 4.9 хувь болж, 0.9 нэгжээр тус тус өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 77.8 хувийг хөнгөн, 13.6 хувийг хүндэвтэр, 5.8 хувийг хүнд, 2.8 хувийг онц хүнд ангиллын гэмт хэрэг эзэлж, 56.6 хувь нь Улаанбаатар хотод, 43.4 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.



1.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас бүртгэгдсэн хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл,

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг хэрэг 1285 буюу 94.7 хувийг, хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг хэрэг 32 буюу 2.4 хувийг, нийгмийн аюулгүй байдлын эсрэг хэрэг 29 буюу 2.1 хувийг, өмчлөх эрхийн эсрэг хэрэг 9 буюу 0.7 хувийг, хүн амын эрүүл мэндийн эсрэг хэрэг 1 буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна.

1.3 Гэмт хэргийг эрүүгийн зүйл ангиар авч үзвэл:

Бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 1250 буюу 92.2 хувийг, хүнийг санаатай алах хэрэг 29 буюу 2.1 хувийг, танхайрах хэрэг 28 буюу 2. хувийг, хүчиндэх хэрэг 24 буюу 1.8 хувийг, бусад төрлийн хэрэг 25 буюу 1.8 хувийг тус тус эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 104 буюу 7.7 хувийг эмэгтэй хүн, 625 буюу 46.1 хувийг согтуугаар үйлдсэн байна .



1.4 Гэмт хэргийн үйлдэгдсэн хугацаа:

Даваа	233	17.2%
Мягмар	225	16.6%
Лхагва	183	13.5%
Пүрэв	196	14.4%
Баасан	181	13.3%
Бямба	165	12.2%
Ням	173	12.8%

Даваа, Мягмар → 33.8%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр, орон сууцанд 1167 буюу 86.1, гудамж талбайд 70 буюу 5.2, олон нийтийн газарт 34 буюу 2.5, аж ахуйн нэгжид 14 буюу 1.0, нийтийн тээвэрт 6 буюу 0.4, төрийн байгууллагад 5 буюу 0.4 хувь, төрийн бус байгууллагад 3 буюу 0.2 хувь, бусад газар 57 буюу 4.2 хувь нь тус тус үйлдэгджээ.

Хоёр. Гэмт хэргийн хохирогчид

2015 онд бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт 27948 иргэн өртөж хохирсноос гэр бүлийн хүчирхийлэлд 1307 иргэн өртөж хохирсоны 88.1 хувь нь эмэгтэй хүн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн насны ангилал



Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн дотор эхнэр 827, хамтран амьдрагч 190, нөхөр 44, дагавар хүүхэд 36, төрсөн хүүхэд 35, хадам эцэг 22, төрсөн эцэг 21, төрсөн дүү 15, төрсөн ах 12, өвөг эцэг 4, бусад 101 хүн байна.

Хохирогч хүчирхийлэлд өртсөн байдлыг хугацаагаар нь ангилж үзвэл 0-1 жил 801, 1-3 жил 126, 3-5 жил 34, 5-8 жил 16, 8-аас дээш жил 30 хүн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас 24 хүн нас барж, 1154 хүн гэмтэж, иргэдэд 657.8 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирсаны 599.4 буюу 91.1 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлжээ.

Хүчирхийлэлд өртсөн иргэдийн нийгмийн байдал



Гурав. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 24857 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 1323 буюу 5.3 хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд, тэдгээрийн 41.8 хувь нь согтуугаар холбогдон шалгагджээ.

3.1 Гэр бүлийн хүчирхийлэлд холбогдогчдыг нас, нийгмийн байдал, боловсрол:

- төрийн албан хаагч 71,
- хувийн хэвшлийн байгууллагын ажилтан 148,
- хувиараа хөдөлмөр эрхлэгч 277,
- төрийн бус байгууллагын ажилтан 32,
- малчин 113,
- оюутан 6,
- тэнэмэл 2,
- ажилгүй 674 хүн,
- 2.8 хувь нь боловсролгүй,
- 7.1 хувь нь бага,
- 19.2 хувь нь суурь,
- 44.4 хувь нь бүрэн дунд,
- 0.2 хувь нь техникийн болон мэргэжлийн,
- 3.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд,
- 22.8 хувь нь дээд боловсролтой хүн байна.



Дөрөв. Захиргааны зөрчлийн шийдвэрлэлт

Улсын хэмжээнд 2015 онд 1423088 захиргааны зөрчил бүртгэгдсэний 1453 буюу 0.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж, зөрчил гаргасан 898 хүнд 11.3 сая төгрөгөөр торгох, 555 хүнд баривчлах шийтгэлийг завснаар ногдуулсан байна.

Зөрчлийн 1391 буюу 95.7 хувийг танхайрах, 56 буюу 3.9 хувийг согтуурах, 6 буюу 0.4 хувийг цагдаагийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх зөрчил тус тус эзэлж байна.

4.1 Зөрчил үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•241 буюу 16.6 %
Мягмар	•241 буюу 16.6 %
Лхагва	•237 буюу 16.2 %
Пүрэв	•235 буюу 16.2 %
Баасан	•183 буюу 12.6 %
Бямба	•136 буюу 9.4 %
Ням	•180 буюу 12.4 %

Зөрчил үйлдэгдсэн цаг
• 06.00-12.00 цагт 8.3 %
• 13.00-18.00 цагт 21.7 %
• 19.00-00.00 цагт 60.8 %
• 01.00-05.00 цагт 9.2 %

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 91.1 хувь нь гэр, орон сууцанд, 6.1 хувь нь гудамж талбайд, 1.5 хувь нь олон нийтийн газарт, 0.1 хувь нь тус бүр аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагад, 1.0 хувь нь бусад газарт тус тус үйлдэгджээ.

4.2 Зөрчил үйлдэгчдийн нас, нийгмийн байдал:





Зөрчил үйлдэгчдийн 1427 буюу 98.2 хувь нь эрэгтэй, 26 буюу 1.8 хувь нь эмэгтэй хүн байна. Зөрчил үйлдэгчдийн 1206 буюу 83.0 хувь нь согтуугаар зөрчил үйлдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн захиргааны зөрчилд өртсөн 331 иргэнийг насны байдлаар нь авч үзвэл,

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн насны ангилал



Эдгээр иргэдийн дотор төрийн албан хаагч 17, хувийн хэвшлийн байгууллагын ажилтан 41, хувиараа хөдөлмөр эрхлэгч 61, малчин 6, оюутан 4, ажилгүй 156, бусад 46 хүн бүртгэгдсэн байна.

§5.5. Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг	7976	8830	854	10.7
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	29.2	31.8	2.6 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 5.9 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 17.6 хувиар,
- хүнд гэмт хэрэг 1.3 хувиар тус тус өсч,
- онц хүнд гэмт хэрэг 5.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.3 Гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Хүчиндэх гэмт хэргийн 60.2 хувь нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 56.9 хувь нь, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн 53.1 хувь нь, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн 50.0 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 43.2 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 42.1 хувь нь, дээрэмдэх гэмт хэргийн 18.1 хувь нь, танхайрах гэмт хэргийн 16.9 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 16.7 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 16.4 хувь нь, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 2.4 хувь нь гэр орон сууцанд үйлдэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	• 1519	17.2%
Мягмар	• 1342	15.2%
Лхагва	• 1300	14.8%
Пүрэв	• 1263	14.3%
Баасан	• 1292	14.6%
Бямба	• 1098	12.4%
Ням	• 1016	11.5%

Даваа, Мягмар: 32.2 %

Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт гэр орон сууцад үйлдэгдсэн гэмт хэрэг 101 буюу 7.1 хувиар, Мягмарт 110 буюу 8.9 хувиар, Лхагвад 119 буюу 10.1 хувиар, Пүрэвд 169 буюу 15.4 хувиар, Баасанд 75 буюу 8.0 хувиар, Бямбад 109 буюу 9.2 хувиар, Нямд 171 буюу 18.4 хувиар тус тус өсчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 215 буюу 13.0 хувиар, 14-19 цагийн хооронд 427 буюу 21.1 хувиар, 22-06 цагийн хооронд 230 буюу 8.4 хувиар тус тус өсч, 19-22 цагийн хооронд 18 буюу 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэр орон сууцанд үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Хувийн байшинд 435 буюу 23.5 хувиар, гэрт 293 буюу 9.6 хувиар, орон сууцны байранд 110 буюу 6.1 хувиар, амбаарт 23 буюу 21.1 хувиар, бусад 17 буюу 4.2 хувиар, орцонд 15 буюу 5.3 хувиар, гараажид 13 буюу 10.9 хувиар, хаусанд 11 буюу 52.4 хувиар, подвальд 4 буюу 4.7 хувиар тус тус өсч, зуслангийн байшинд 29 буюу 14.3 хувиар, агуулахад 4 буюу 10.5 хувиар, тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/

Улаанбаатар хотод 64.4 хувь нь аймгуудад 35.6 хувь нь бүртгэгдсэн байна.



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 7448 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.7 хувиар өссөн байна. Үүнээс 1028 буюу 5.1 хувь нь эмэгтэй, 2273 буюу 85.4 хувь нь эрэгтэй, тэдний 129 буюу 4.8 хувь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 13.5 хувиар, эрэгтэй 8.1 хувиар, хүүхэд 27.7 хувиар тус тус өссөн байна.

2.1 Нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 7 аж ахуйн нэгж, байгууллага, 8938 иргэн хохирч, үүнээс 197 хүн нас барж, 3607 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 84 буюу 29.9 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 66 буюу 1.9 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 16.8 тэрбум төгрөгийн хохирлын 45.7 хувийг нөхөн төлүүлж, 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§5.6. Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг	3781	3625	156	4.1 буурсан
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	13.8	13.1	0.8 нэгжээр буурсан	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хүнд гэмт хэрэг 1.9 хувиар өсч,
- хөнгөн гэмт хэрэг 1.4 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 9.4 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 5.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.3 Гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Танхайрах гэмт хэргийн 24.8 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 17.1 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 15.0 хувь нь, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 13.8 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 13.4 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах 6.0 хувь нь, хүчиндэх 5.7 хувь нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 5.4 хувь нь, дээрэмдэх гэмт хэргийн 4.8 хувь нь, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн 3.5 хувь нь олон нийтийн газарт үйлдэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•596	16.4%
Мягмар	•537	14.8%
Лхагва	•484	13.4%
Пүрэв	•521	14.4%
Баасан	•529	14.6%
Бямба	•479	13.2%
Ням	•479	13.2%

Даваа, Мягмар → 31.2



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Ням гарагт олон нийтийн газарт үйлдэгдсэн хэрэг 18 буюу 3.9 хувиар өсч, Даваа гарагт 47 буюу 7.3 хувиар, Лхагвад 95 буюу 16.4 хувиар, Пүрэвт 6 буюу 1.1 хувиар, Баасанд 2 буюу 0.4 хувиар, Бямбад 24 буюу 4.8 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 54 буюу 3.9 хувиар өсч, 06-14 цагийн хооронд 52 буюу 7.4 хувиар, 14-19 цагийн хооронд 90 буюу 8.1 хувиар, 19-22 цагийн хооронд 68 буюу 11.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэргийн үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Ресторан, зоогийн газарт үйлдэгдсэн хэрэг 54 буюу 22.7 хувиар, түцэнд 12 буюу 85.7 хувиар, бөөний худалдааны төвд 5 буюу 2.0 хувиар, авто вокзал 5 буюу 26.3 хувиар тус тус өсч, дэлгүүрт 67 буюу 9.2 хувиар, баарaнд 50 буюу 5.7 хувиар, бусад газарт 28 буюу 4.7 хувиар, үзвэрийн газарт 22 буюу 31.0 хувиар, төмөр замын вокзал 16 буюу 43.2 хувиар, зочид буудалд 15 буюу 3.6 хувиар, нисэх онгоцонд 13 буюу 76.5 хувиар, саунд 12 буюу 46.2 хувиар, сувиллын газарт 4 буюу 28.6 хувиар, нийтийн захад 3 буюу 0.7 хувиар, амралтын газарт 2 буюу 2.4 хувиар тус тус буурчээ.

1.6 Гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/

Улаанбаатар хотод 78.4 хувь нь, аймгуудад 21.6 хувь нь бүртгэгдсэн байна.

Орон нутагт бүртгэгдсэн хэргийн гаралт (хувиар)



Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн гаралт (хувиар)



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 3305 хүн гэмтхэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар өссөн байна. Үүнээс 761 буюу 23.0 хувь эмэгтэй, 2544 буюу 77.0 хувь эрэгтэй, тэдний 286 буюу 8.7 хувь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 17.7 хувиар, эрэгтэй 5.1 хувиар буурч, хүүхэд 3.9 хувиар өссөн байна.

2.1 Нас, нийгмийн байдал:



Нийгмийн байдал

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 7 аж ахуйн нэгж, байгууллага, 3677 иргэн хохирч, үүнээс 15 хүн нас барж, 1535 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 9 буюу 37.5 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 43 буюу 2.9 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 10.3 тэрбум төгрөгийн хохирлын 24.0 хувийг нөхөн төлүүлж, 0.7 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§5.7. Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг	521	455	66	-12.7
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	1.9	1.6	1.3 нэгжээр буурсан.	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 14.7 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 11.8 хувиар,
- хүнд гэмт хэрэг 8.1 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 16.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.3 Гэмт хэргийн бүтэц /гэмт хэргийн төрлөөр:/

Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 16.0 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 14.1 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 7.5 хувь нь, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 7.3 хувь нь, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн 2.6 хувь нь, танхайрах гэмт хэргийн 2.0 хувь нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 0.9 хувь нь, дээрэмдэх гэмт хэргийн 0.2 хувь нь, төрийн байгууллагад үйлдэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:





Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Пүрэв гарагт төрийн байгууллагад үйлдэгдсэн хэрэг 20 буюу 33.3 хувиар өсч, Даваа гарагт 18 буюу 16.8 хувиар, Мягмарт 20 буюу 20.8 хувиар, Лхагвад 14 буюу 15.6 хувиар, Баасанд 15 буюу 16.5 хувиар, Бямбад 64 буюу 70.3 хувиар, Нямд 14 буюу 31.1 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд 48 буюу 27.4 хувиар өсч, 14-19 цагийн хооронд 27 буюу 15.1 хувиар, 19-22 цагийн хооронд 11 буюу 27.5 хувиар, 22-06 цагийн хооронд 76 буюу 59.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэргийн үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Захиргааны байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 14 буюу 15.6 хувиар, цагдаад 9 буюу 17.0 хувиар, прокурорт 3 буюу 75.0 хувиар, дипломат төлөөлөгчийн газарт 2 буюу 2.0 дахин, бүртгэлийн албанд 1 буюу 6.3 хувиар тус тус өсч, бусад газарт 26 буюу 15.6 хувиар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд 17 буюу 36.2 хувиар, гаальд 15 буюу 39.5 хувиар, онцгой байдлын албанд 11 буюу 84.6 хувиар, газрын албанд 6 буюу 75.0 хувиар, шүүхэд 5 буюу 23.8 хувиар, нийгмийн даатгалын байгууллагад 3 буюу 27.3 хувиар, халамж үйлчилгээнд 3 буюу 30.0 хувиар, татварт 2 буюу 25.0 хувиар, зэвсэгт хүчин 1 буюу 5.6 хувиар, ашигт малтмал геодези, зураг зүйн алба 1 буюу 33.3 хувиар, музейд 1 буюу 50 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралтыг /нутаг дэвсгэрээр/:

Улаанбаатар хотод 52.0 хувь нь, орон нутагт 48.0 хувь нь бүртгэгдсэн байна.

Орон нутагт бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 364 хүн гэмт хэрэгт шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6 хувиар буурсан. Үүнээс 103 буюу 28.3 хувь нь эмэгтэй, 261 буюу 71.7 хувь нь эрэгтэй, 19 буюу 5.2 хувь хүүхэд байгаа нь мөн үеийн түвшинд, эмэгтэй 20.8 хувиар, эрэгтэй 17.7 хувиар тус тус буурсан байна.

2.1 Нас, нийгмийн байдал:



Нийгмийн байдал

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 14 аж ахуйн нэгж, байгууллага, 359 иргэн хохирч, үүнээс 14 хүн нас барж, 104 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 2 буюу 12.5 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 24 буюу 18.8 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 1.5 тэрбум төгрөгийн хохирлын 43.4 хувийг нөхөн төлүүлж, 0.2 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§5.8. Гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг	5622	5499	-123	-2.2
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	20.6	19.8	- 0.8 нэгжээр буурсан	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 3.5 хувиар өсч,
- хүндэвтэр гэмт хэрэг 2.8 хувиар,
- хүнд гэмт хэрэг 23.9 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 20.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.3 Хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Хүчиндэх гэмт хэргийн 15.8 хувь нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 15.7 хувь нь, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн 6.3 хувь нь, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн 11.8 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 13.1 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 25.8 хувь нь, дээрэмдэх гэмт хэргийн 64.6 хувь нь, танхайрах гэмт хэргийн 43.8 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 65.3 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 14.0 хувь нь, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 2.7 хувь нь гудамж талбайд үйлдэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	• 915	16.6%	32.0
Мягмар	• 845	15.4%	
Лхагва	• 811	14.8%	
Пүрэв	• 844	15.4%	
Баасан	• 789	14.3%	
Бямба	• 656	11.9%	
Ням	• 639	11.6%	



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Лхагва гарагт гудамж, талбайд үйлдэгдсэн хэрэг 8 буюу 1.0 хувиар, Пүрэвт 1 буюу 0.1 хувиар тус тус өсч, Даваа гарагт 24 буюу 2.6 хувиар, Мягмарт 30 буюу 3.4 хувиар, Баасанд 35 буюу 4.2 хувиар, Бямбад 24 буюу 3.5 хувиар, Нямд 19 буюу 2.9 хувиар тус тус буурчээ,

Хэргийг цагаар нь авч үзвэл: 14-19 цагийн хооронд 33 буюу 2.5 хувиар, 19-22 цагийн хооронд 9 буюу 0.9 хувиар тус тус өсч, 06-14 цагийн хооронд 81 буюу 9.0 хувиар, 22-06 цагийн хооронд 84 буюу 3.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Орон сууцны хорооллын гудамжинд 5 буюу 0.3 хувиар, тоглоомын талбайд 19 буюу 37.3 хувиар, ил зогсоолд 78 буюу 15.5 хувиар, цэцэрлэгт хүрээлэнд 5 буюу 10.4 хувиар, автобусны буудалд 16 буюу 4.1 хувиар тус тус өсч, гэр хорооллын гудамжинд 168 буюу 7.7 хувиар, төмөр замд 1 буюу 10.0 хувиар, бусад 77 буюу 9.8 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:

Улаанбаатар хотод 22.3 хувь нь, аймгуудад 15.2 хувь нь бүртгэгдсэн байна.

Орон нутагт бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 5127 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 105 буюу 2.1 хувиар өссөн байна. Үүнээс 570 буюу 11.1 хувь нь эмэгтэй, 4557 буюу 88.9 хувь нь эрэгтэй, тэдний 402 буюу 7.8 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 2.3 хувиар, эрэгтэй 2.1 хувиар, хүүхэд 8.6 хувиар тус тус өссөн байна.

2.1 Нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 5609 иргэн хохирч, үүнээс 64 хүн нас барж, 3017 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 10 буюу 13.5 хувиар, гэмтсэн хүний тоо 46 буюу 1.5 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 7.6 тэрбум төгрөгийн хохирлын 56.3 хувийг нөхөн төлүүлж, 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.

§6. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ

§6.1. Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Ажилгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг	10505	11164	659	6.3
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	38.5	40.2	1.8 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 6.0 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 9.0 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 5.2 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 0.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.3 Гэмт хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэргийн 4.2 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 32.9 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 39.0 хувь нь, бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийн 40.6 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 41.8 хувь нь, дээрэмдэх гэмт хэргийн 42.8 хувь нь, танхайрах гэмт хэргийн 43.6 хувь нь, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 44.1 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 46.0 хувь нь, хүчиндэх гэмт хэргийн 50.5 хувь нь, хүнийг санаатай алах гэмт хэргийн 53.9 хувийг эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс үйлдсэн байна.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 154 буюу 8.6 хувиар, Мягмарт 142 буюу 8.8 хувиар, Лхагвад 30 буюу 1.8 хувиар, Пүрэвт 195 буюу 13.5 хувиар, Баасанд 4 буюу 0.3 хувиар, Бямбад 110 буюу 9.0 хувиар, Нямд 24 буюу 2.0 хувиар тус тус өсчээ,

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 160 буюу 7.4 хувиар, 14-19 цагийн хооронд 366 буюу 12.8 хувиар, 19-22 цагийн хооронд 20 буюу 1.1 хувиар, 22-06 цагийн хооронд 113 буюу 3.1 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Даваа	1939	17.4%	33.1
Мягмар	1752	15.7%	
Лхагва	1652	14.8%	
Пүрэв	1642	14.7%	
Баасан	1597	14.3%	
Бямба	1331	11.9%	
Ням	1251	11.2%	



1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 562 буюу 15.8 хувиар, гудамж талбайд 14 буюу 0.6 хувиар, нийтийн тээвэрт 21 буюу 20.4 хувиар, төрийн бус байгууллагад 9 буюу 10.2 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 118 буюу 17.4 хувиар, авто замд 71 буюу 9.7 хувиар тус тус өсч, олон нийтийн газарт 16 буюу 1.1 хувиар, төрийн байгууллагад 10 буюу 8.1 хувиар, бусад газарт 110 буюу 7.2 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:

Улаанбаатар хотод 61.4 хувь нь аймгуудад 38.5 хувь нь бүртгэгдсэн байна.





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт ажилгүй 12526 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 868 буюу 7.4 хувиар өссөн байна. Үүнээс 1887 буюу 15.1 хувь нь эмэгтэй, 10639 буюу 84.9 хувь нь эрэгтэй, тэдний 460 буюу 3.7 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 4.2 хувиар, эрэгтэй 8.0 хувиар, хүүхэд 3.7 хувиар тус тус өссөн байна.

2.1 Нас, боловсрол:





Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 34 аж ахуйн нэгж, байгууллага, 11578 иргэн хохирч, үүнээс 249 хүн нас барж, 4845 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 25 буюу 9.1 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 73 буюу 1.5 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 52.8 тэрбум төгрөгийн хохирлын 34.7 хувийг нөхөн төлүүлж, 5.3 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§6.2. Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 3782 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 137 хэргээр буюу 3.6 хувиар, Улаанбаатар хотын хэмжээнд 134 хэргээр буюу 5.4 хувиар тус тус өссөн байна.

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг	3645	3782	137	3.7
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	13.3	13.6	1.3 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 7.1 хувиар,
- хүнд гэмт хэрэг 18.0 хувиар тус тус өсч,
- хүндэвтэр гэмт хэрэг 2.6 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 11.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.4 Гэмт хэргийн бүтэц /гэмт хэргиын төрлөөр/:

Хүнийг санаатай алах гэмт хэргийн 0.6 хувь нь, Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 30.1 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 15.7 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 0.2 хувь нь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн 0.5 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 20.1 хувь нь, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийн 4.3 хувь нь, банкны тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн 0.1 хувь нь, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн 0.3 хувь нь, танхайрах гэмт хэргийн 3.0 хувь нь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн 4.0 хувь, бусад төрлийн хэрэг 21.1 хувь нь эмэгтэй хүн үйлдсэн хэрэг бүртгэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•679	18.0%
Мягмар	•625	16.5%
Лхагва	•568	15.0%
Пүрэв	•560	14.8%
Баасан	•585	15.5%
Бямба	•417	11.0%
Ням	•348	9.2%

34.5



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 86 буюу 14.5 хувиар, Мягмарт 44 буюу 7.6 хувиар, Пүрэвт 56 буюу 11.1 хувиар, Баасанд 50 буюу 9.3 хувиар тус тус өсч, Лхагвад 48 буюу 7.8 хувиар, Бямбад 7 буюу 1.7 хувиар, Нямд 44 буюу 11.2 хувиар тус тус буурчээ.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 61 буюу 5.6 хувиар, 14-19 цагийн хооронд 63 буюу 5.0 хувиар, 19-22 цагийн хооронд 17 буюу 3.4 хувиар тус тус өсч, 22-06 цагийн хооронд 4 буюу 0.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд 31 буюу 3.1 хувиар, гудамж талбайд 3 буюу 0.6 хувиар, нийтийн тээвэрт 14 буюу 42.4 хувиар, төрийн бус байгууллагад 11 буюу 14.9 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 122 буюу 24.9 хувиар, бусад газарт 17 буюу 4.6 хувиар тус тус өсч, олон нийтийн газарт 51 буюу 6.4 хувиар, төрийн байгууллагад 9 буюу 6.8 хувиар авто замд 1 буюу 0.5 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:





Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 3782 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 4.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс 100 буюу 2.6 хувийг 14-17 насны хүүхэд эзэлж байна.

2.1 Нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 2236 иргэн, 17 аж ахуй нэгж байгууллага хохирч, үүнээс 42 хүн нас барж, 950 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 15 буюу 35.7 хувиар, гэмтсэн хүн 8 буюу 0.8 хувиар тус тус өссөн байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 15.6 тэрбум төгрөгийн хохирлын 46.4 хувийг нөхөн төлүүлж, 20.0 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§6.3. Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэрэг	1059	1144	85	8.0
2	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь	3.8	4.2	1.4 нэгжээр өссөн	

1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:

Гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 3.6 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 13.8 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 3.6 хувиар буурсан,
- онц хүнд гэмт хэрэг мөн үеийн түвшинд байна.



1.3 Хэргийн бүтэц гэмт хэргийн төрлөөр:

Хүнийг санаатай алах гэмт хэргийн 0.3 хувь нь, бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэргийн 20.0 хувь нь, хүчиндэх гэмт хэргийн 2.2 хувь нь, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн 56.6 хувь нь, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэргийн 2.1 хувь нь, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэргийн 6.4 хувь нь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийн 1.2 хувь нь, танхайрах гэмт хэргийн 5.6 хувь нь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн 1.5 хувьд, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах хадгалах, тээвэрлэх, илгээх борлуулах гэмт хэргийн нь 0.6 хувьд нь, бусад төрлийн хэрэгт 3.5 хувь үйлдэгджээ.

1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа:

Даваа	•184	16.1%
Мягмар	•181	15.9%
Лхагва	•168	14.7%
Пүрэв	•171	14.9%
Баасан	•168	14.7%
Бямба	•147	12.8%
Ням	•125	10.9%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Даваа гарагт үйлдэгдсэн хэрэг 6 буюу 3.4 хувиар, Мягмарт 24 буюу 15.3 хувиар, Пүрэвт 10 буюу 6.2 хувиар, Баасанд 10 буюу 6.3 хувиар, Бямбад 38 буюу 34.9 хувиар тус тус өсч, Лхагвад 3 буюу 1.8 хувиар буурч, Ням гарагт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 49 буюу 27.8 хувиар, 14-19 цагийн хооронд 12 буюу 4.0 хувиар, 19-22 цагийн хооронд 5 буюу 2.9 хувиар, 22-06 цагийн хооронд 19 буюу 4.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 85 буюу 30.8 хувиар, нийтийн тээвэрт 11 буюу 4.7 дахин, төрийн бус байгууллагад 2 буюу 11.1 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 5 буюу 5.7 хувиар, олон нийтийн газарт 22 буюу 11.1 хувиар, авто замд 6 буюу 37.5 хувиар тус тус өсч, төрийн байгууллагад 2 буюу 11.8 хувиар, гудамж талбайд 16 буюу 4.9 хувиар, бусад газарт 28 буюу 24.3 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:

Насанд хүрээгүй хүн үйлдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 1144 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 85 хэргээр буюу 8.0 хувиар, Улаанбаатар хотын хэмжээнд 85 хэргээр буюу 14.2 хувиар тус тус өссөн байна.

Орон нутагт бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

Нийт 1402 хүүхэд гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 152 буюу 12.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт холбогдогчийн 100 буюу 7.1 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 буюу 23.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаадын 2 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.

Гурав. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Гэмт хэргийн улмаас 1477 иргэн хохирч, үүнээс 100 хүн нас барж, 784 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нас барсан хүн 1 буюу 0.1 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 33 буюу 4.0 хувиар буурсан байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 427.5 сая төгрөгийн хохирлын 74.9 хувийг нөхөн төлүүлж, 43.3 тэрбум төгрөгийн хөрөнгө битүүмжилжээ.



§6.4. Гадаадын иргэдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдал

1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гадаадын иргэдээс үйлдэгдсэн гэмт хэрэг	78	84	6	7.7

1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангиллаар:

Гадаадын иргэдээс үйлдэгдсэн гэмт хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хөнгөн гэмт хэрэг 2.9 хувиар,
- хүндэвтэр гэмт хэрэг 38.9 хувиар,
- онц хүнд гэмт хэрэг 18.2 хувиар тус тус өсч,
- хүнд гэмт хэрэг 26.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



1.3 Гадаадын иргэдээс үйлдэгдсэн хэргийн бүтэц /гэмт хэргийн төрлөөр/:

Гэмт хэргийн 1.2 хувийг хүнийг санаатай алах гэмт хэрэг, 3.6 хувийг бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах тус бүр гэмт хэрэг, 6.0 хувийг бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэрэг, 21.4 хувийг бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг, 31.0 хувийг бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг, 33.2 хувийг бусад төрлийн хэрэг тус тус эзэлж байна.

1.4 Гадаадын иргэдээс үйлдэгдэгдсэн гэмт хэргийн хугацаа:

Даваа	• 10	11.9%
Мягмар	• 11	13.1%
Лхагва	• 16	19.0%
Пүрэв	• 13	15.5%
Баасан	• 15	17.9%
Бямба	• 7	8.3%
Ням	• 12	14.3%



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Баасан гарагт үйлдэгдсэн хэрэг 1 буюу 7.1 хувиар, Нямд 3 буюу 33.3 хувиар, Лхагвад 11 буюу 3.2 дахин тус тус өсчээ, Мягмар гарагт 4 буюу 26.7 хувиар, Бямбад 5 буюу 41.7 хувиар тус тус буурч, Даваа, Пүрэвт тус бүр мөн үеийн түвшинд байна.

Хэргийг цагаар нь авч үзвэл: 06-14 цагийн хооронд үйлдэгдсэн хэрэг 17 буюу 85.0 хувиар, 19-22 цагийн хооронд 2 буюу 20.0 хувиар тус тус өсч, 14-19 цагийн хооронд 5 буюу 18.5 хувиар, 22-06 цагийн хооронд 8 буюу 38.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар:

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад: Гэр орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 4 буюу 40.0 хувиар, гудамж талбайд 3 буюу 37.5 хувиар, олон нийтийн газарт 3 буюу 33.3 хувиар, авто замд 1 буюу 10.0 хувиар, төрийн байгууллагад 1 буюу 2.0 дахин тус тус өсч, төрийн бус байгууллагад 1 буюу 50.0 хувиар, аж ахуйн нэгж, байгууллагад 2 буюу 9.5 хувиар, бусад газарт 4 буюу 23.5 хувиар тус тус буурсан байна.

1.6 Гадаадын иргэдээс үйлдэгдсэн гэмт хэргийн гаралт /нутаг дэвсгэрээр/:

Улаанбаатар хотод 71.4 хувь нь, аймгуудад 27.4 хувь нь бүртгэгдсэн байна.

Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

2.1 Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан гадаадын иргэд:

Нийт гадаадын 92 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 иргэн буюу 5.7 хувиар өссөн байна. Үүнээс 5 буюу 5.4 хувь нь эмэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд, 87 буюу 94.6 хувь нь эрэгтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 буюу 6.1 хувиар өссөн байна.

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн	87	92	5	5.7

2.2 Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэдийн иргэншил:

Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан гадаадын иргэдийн дотор БНХАУ-ын иргэн 45, БНСУ-ын 20, ОХУ-ын 14, Вьетнам, Казахстан улсын тус бүр 2, Австрали, АНУ, Болив, Канад, Куба, Тайван, Турк, Франц, Япон улсын тус бүр нэг иргэн байна.

2.3 Нас, нийгмийн байдал:



Гурав. Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэд

3.1 Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэд:

№	Үзүүлэлт	2014	2015	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэн	176	193	17	9.7

3.2 Гэмт хэргийн халдлагад өртсөн гадаадын иргэний иргэншил:

Гэмт хэрэгт өртөж хохирсон гадаадын иргэдээс БНХАУ-ын иргэн 90, БНСУ-ын 29, ОХУ-ын 19, АНУ-ын 11, Вьетнам улсын 8, Герман 5, Австрали улсын 4, Австри, Франц, Япон улсын тус бүр 3, Их Британи, Колумб, Швед, Энэтхэг улсын тус бүр 2, Голланд, Дани, Израйл, Канад, Польш, Сири, Турк, Узбекстан, Швейцарь, Чех улсын тус бүр нэг иргэн байна.

3.3 Нас, нийгмийн байдал:



§6.5. Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

1.1 Гэмт хэрэг үйлдсэн урьд нь ял шийтгэгдсэн хүн:

2015 онд урьд нь ял шийтгэгдсэн 1455 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 354 буюу 32.2 хувиар өссөн. Нийт гэмт хэрэгт холбогдсон хүмүүст эзлэх хувийн жин 5.8 хувь байна.

1.2 Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс:

1 буюу 0.1 хувь нь биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохин байгуулах, 1 буюу 0.1 хувь нь бусдыг болгоомжгүй алах, 1 буюу 1.0 хувь бусдыг амиа хорлоход хүргэх, 2 буюу 0.1 хувь нь прокурорын хяналт, шүүх, цагдан хорих ангиас оргох, 2 буюу 0.1 хувь нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах, 4 буюу 0.2 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, 4 буюу 0.2 хувь нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомж зөрчих, 5 буюу 0.3 хувь нь зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах, 11 буюу 0.7 хувь нь төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх, доромжлох, 12 буюу 0.8 хувь нь бусдын эд хөрөнгийг булаах, 20 буюу 1.3 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 20 буюу 1.4 хувь нь хүчиндэх, 25 буюу 1.7 хувь нь хүнийг санаатай алах, 52 буюу 3.5 хувь нь дээрэмдэх, 79 буюу 5.4 хувь нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 79 буюу 5.4 хувь нь танхайрах, 309 буюу 21.2 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 756 буюу 52.0 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, 72 буюу 4.5 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.

1.3 Урьд нь ял шийтгэгдсэн хүмүүсийн гэмт хэрэгт холбогдсон газар

Улаанбаатар хотод 55.2 хувь нь, аймгуудад 44.8 хувь нь бүртгэгдсэн байна.

Орон нутагт бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



Улаанбаатар хотод бүртгэгдсэн хэргийн гаралт /хувиар/



1.4 Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал:



1.5 Дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг боловсролоор нь авч үзвэл:

43 буюу буюу 0.2 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн дунд, 103 буюу 7.0 хувь нь дээд, 139 буюу 9.5 хувь нь боловсролгүй, 216 буюу 14.8 хувь нь бага, 443 буюу 30.3 хувь нь суурь, 511 буюу 35.1 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Эдгээр хүмүүсийн 42 буюу 2.9 хувь нь насанд хүрээгүй, 79 буюу 5.4 хувь нь эмэгтэй хүн, 411 буюу 28.2 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Гадаадын 1 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Захиргааны хяналтанд байгаа хүмүүсээс гэмт хэрэг үйлдсэн байдал

2015 онд захиргааны хяналтанд байсан 144 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 6 буюу 4.3 хувиар өсч, нийт гэмт хэрэгт холбогдсон хүмүүс дотор 0.6 хувийг эзэлж байна.

Захиргааны хяналтанд байсан хүмүүсээс: 1 буюу 0.6 хувь нь прокурорын хяналт, шүүх, цагдан хорих ангиас оргох, 1 буюу 0.6 хувь нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих, 3 буюу 2.1 хувь нь хүчиндэх, 4 буюу 2.7 хувь нь бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, 6 буюу 4.1 хувь нь дээрэмдэх, 9 буюу 6.2 хувь нь танхайрах, 21 буюу 14.6 хувь нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 45 буюу 31.5 хувь нь бусдын эд хөрөнгийг хулгайлах, 54 буюу 37.6 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагджээ.